



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 45,000,000.00 (дөчин таван сая) төгрөгийн балансын үнэ, 33,125,000.00 (гучин гурван сая нэг зуун хорин таван мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан эд хөрөнгийг Говь-Алтай аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Ч.Гүнсэнхорол, Говь-Алтай аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал Г.Гансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны дүгээр сарын 1-ний өдрийн
1.02 дугаар тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ²⁹⁸³

Д/д	Суудлын автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Суудлын автомашин Лексус-470, ӨВА 44-74, JТ6НТ00W6Х0046433	1999/2014	45,000,000.00	33,125,000.00	11,875,000.00
	Нийт дүн		45,000,000.00	33,125,000.00	11,875,000.00
			(дөчин таван сая)	(гучин гурван сая нэг зуун хорин таван мянга)	(арван нэгэн сая найман зуун далан таван мянга)